

Үйлдвэрийн ажилтнуудад зориулсан мэдээлэл

www.aiche.org/ccps/process-safety-beacon

Өндөр Хэмийн Ажилд зөвхөн Гагнах, Халаах, Өнгөлөх үйлдлүүд багтдаггүй. 2022 оны 03-р сар



Зураг 1:
Халаагч буюу
(Галын эх
үүсвэр)



Зураг 2: Галын дараа

2020 оны 09-р сарын 21-ний өдөр цаасны үйлдвэрт хуванцар бүтэцтэй шугаман тулгуурын гадаргууг бүрэхэд ашиглаж байсан хувинтай шатамхай бодис буюу резин шатсаны улмаас гал гарсан (Зураг 1). Галын утаа болон угаарын улмаас гэрээт компанийн хоёр ажилтан амиа алдсан. Тус ослоос олон сургамжийг авч болох ч энд зөвхөн Өндөр Хэмийн Ажлын хяналт алдагдсан явдлын талаар онцоллоо.

Тухайн үед үйлдвэр түр хугацаагаар зогссон байсан бөгөөд засварын ажил хийгдэж байсан аж (Зураг 3).



Зураг 3: Шугаман тулгуур
(хэмжээг харьцуулсан)

Цайруулах бодисын шугаман тулгууруудад хоёр ширхэг Хязгаарлагдмал Орчинд Нэвтрэх Зөвшөөрлийн дагуу засварын ажлууд хийгдсэн ба аль алинд нь Өндөр Хэмийн Ажлын төлөвлөгөө болон зөвшөөрөл байгаагүй. Шугаман тулгуурын дотор шатамхай материал байгаагүй боловч Эсрэг Урсгалын Шугаман Тулгуурын хуванцар хана шатамхай бүтэцтэй байсан.

Гал гарсан өдөр Эсрэг Урсгалын Шугаман Тулгуур (зүүн) дээр ажиллаж байсан ажилчид сэрүүн температурын улмаас резинийг зохих ёсоор ашиглаж чадахгүй байсан. Тэд тулгуурын гаднах цилиндрин халаагуурыг олж чадаагүй учир ажлын талбайд байсан (улаанаар тэмдэглэсэн) бодисын хувинд зориулагдсан халаагч буюу (Зураг 1) ашиглахаар шийдсэн.

Гэвч халаагч буюу санамсаргүйгээр резинтэй хувинд унагаах үед уг шатамхай бодис шатсан. Багийн ажилчдад гал унтраагуур байгаагүй бөгөөд гал улам тэлсээр хуванцар хананы гадаргууг шатаасан учир ханатай холбогдсон Доош Урсгалын Шугаман Тулгуур дээр ажиллаж байсан хоёр ажилтан (баруун; ногооноор тэмдэглэсэн) зугатаж амжилгүй хийн угаарт өртсөн байна.

https://www.csb.gov/assets/1/20/evergreen_investigation_report_final.pdf?16709

Та мэдэх үү?

Гагнуур, халуун зүсэлт, өнгөлгөөний процесс нь Өндөр Хэмийн Ажилтай холбоотой түгээмэл эрсдлүүдийг учруулдаг. Учир нь эдгээр процессын үед “оч үүсдэг” ба тэдгээр нь хол зайд ч үсрэх боломжтой байдаг.

Өөр олон багаж хэрэгслийг (цахилгаан болон зарим гар багаж) ашиглах үед халуун хий эсвэл моторт багнаас үсэрсэн оч зэргээс галын аюул үүсдэг. Батареягаар ажилладаг багаж хэрэгслийн давуу тал, хэрэглээ өсөх тусам галын эрсдэл нэмэгдэж байна.

Электрон төхөөрөмж (камер, тестер, таблет гэх мэт) ашиглах үед тодорхой шалгууруудын дагуу баталгаажуулалт шаардлагатай байдаг.

Дээрх аюулуудыг хянахын тулд зөвшөөрөл олгохын өмнө Өндөр Хэмийн Ажлын нарийн төлөвлөгөө боловсруулж, аюулгүйн хяналтыг хэрэгжүүлэх ёстой.

Заримдаа гэрээт ажилтнууд өөрсдийн багаж, барилгын материалыг ажлын талбайд авчирснаас үүдэлтэй аюул эрсдэл учирч болзошгүй.

Галын улмаас хүн гэмтэж, амь нас үрэгдээгүй тохиолдолд ч компанид их хэмжээний мөнгөн хохирол, үйл ажиллагааны саатал үүсэх боломжтой.

Хязгаарлагдмал Орчны Ажил бол үйлдвэрлэлийн салбарын хамгийн өндөр эрсдэлтэй ажлуудын нэг бөгөөд олон хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулдаг.

Та юу хийж болох вэ?

Хэрэв та ажлын зөвшөөрөл олгодог, хяналт тавьдаг бол ажил гүйцэтгэх ажилтнуудын хийх зүйлс болон арга барил, ашиглах материал, багаж төхөөрөмжийн талаар сайн мэдэж байх хэрэгтэй.

Зөвшөөрөл олгогч процесстой холбоотой аюул эрсдлүүдээс ажилтнуудыг хамгаалах үүрэгтэй. Гэхдээ гэрээт ажилтнуудын ажлын талбайд санамсаргүй авчирч болзошгүй аюулуудаас мөн сэрэмжилж, компанийн байгууламжуудыг хамгаалах ёстой.

Ажлын анхны төлөвлөгөөнд ямар нэгэн өөрчлөлт орсон тохиолдолд зөвшөөрөл олгогчтой дахин уулзаж, зөвшөөрөл болон хяналтын арга хэмжээнүүдийг өөрчлөх шаардлагатай эсэхийг бататгах ёстой гэдгийг ажилтнуудад сануулах хэрэгтэй.

Оч үсэргэдэггүй байлаа ч цахилгаан хэрэгсэл ашиглах нь Өндөр Хэмийн Ажил мөн!